



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 11 сарын 07 өдөр

Дугаар А/68

Улаанбаатар хот

Ажлын дэд хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 176 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн салбарт үүсээд байгаа нөхцөл байдалтай холбогдуулан тус салбарын хэмжээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, санхүүжилт, чанар, хүртээмж, үр дүнгийн байдлыг шалгаж, санал дүгнэлт гаргах ажлын хүрээнд Нийслэлийн түргэн тусламжийн төв, Дундговь аймгийн Нэгдсэн эмнэлэг дээр ажиллах Ажлын дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

- Ахлагч: - Дарга Б.Цэнгэл
- Дэд ахлагч: - Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Н.Ганболд
- Гишүүд: - Сангийн яамны Санхүүгийн хяналт шалгалтын хэлтсийн ахлах шинжээч, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Н.Батбаатар
- Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын ахлах мэргэжилтэн С.Цогзолмаа
- Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газрын мэргэжилтэн Б.Батчимэг
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эрүүл мэндийн хяналтын эмчилгээний чанарын хяналтын улсын ахлах байцаагч Н.Долгорсүрэн

132013352

ТӨБЗГ тушаал-/2022

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн Тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан ахлах мэргэжилтэн Х.Энхчимэг

- Стандарт, хэмжил зүйн газрын Хэмжих хэрэгсэл, шалгалт баталгаажуулалтын газрын мэргэжилтэн С.Баяржаргал

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн Д.Цэрэнлхам


Нарийн бичгийн дарга:

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн Дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн Г.Туул

2. Ажлын дэд хэсгийн удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Ажлын хэсгийн удирдамжийн дагуу шалгалтын ажлыг зохион байгуулж, дүнг 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн дотор танилцуулахыг Ажлын дэд хэсэг (Н.Ганболд)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын  
газрын даргын 2022 оны 10 дүгээр сарын  
02-ны өдрийн 4/68 дугаар тушаалын хавсралт

## АЖЛЫН ДЭД ХЭСГИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

### 1. Зорилго

Эрүүл мэндийн салбарт үүсээд байгаа нөхцөл байдалтай холбогдуулан тус салбарын хэмжээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, санхүүжилт, чанар, хүртээмж, үр дүнгийн байдлыг шалгаж саналт дүгнэлт гаргахад оршино.

### 2. Шалгалтын ажлын хамрах хүрээ, хуваарь:

№	Шалгалтын чиглэл	Хариуцан шалгах байгууллага
<b>Байгууллагын үндсэн үйл ажиллагаа, ил тод, нээлттэй байдлыг шалгах ажлын хүрээнд:</b>		
1	Эрүүл мэндийн тухай хууль	ЭМЯ СХЗГ МХЕГ
2	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль	
3	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль	
4	Хэмжил зүйн тухай хууль	
5	Төсвийн тухай хууль	СЯ
6	Эрүүл мэндийн даатгалын тухай хууль	ЭМЯ
7	Шилэн дансны тухай хууль	ЭЗХЯ
8	Төрийн албаны тухай хууль	ТӨБЗГ
9	Хөдөлмөрийн тухай хууль	
10	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль	
11	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;	ЭЗХЯ, ТӨБЗГ
12	Эмчилгээ, үйлчилгээний чанарын стандартууд	СХЗГ
13	Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн чиглэлээр гарсан тушаал, шийдвэрийн хэрэгжилт	МХЕГ
<b>Гүйцэтгэлийн санхүүжилтийн хэрэгжилтийн байдлыг шалгах хүрээнд дараах үйл ажиллагааг шалгах ажлын хүрээнд:</b>		
1	Гүйцэтгэлийн санхүүжилтийн өнөөгийн нөхцөл, тулгамдаж буй асуудлууд	ЭМЯ СЯ
2	Зардлын төлбөрийг Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт, түүний гүйцэтгэл	
3	Цалин хөлс тогтоож, олгосон байдал	
4	Гүйцэтгэлийн санхүүжилтийн хүрээнд ажилтнуудын нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэсэн байдал.	

<b>Удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцийн байдлыг шалгах хүрээнд дараах үйл ажиллагааг шалгах ажлын хүрээнд:</b>		
1	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлагналт	ЭЗХЯ
2	Хүний нөөцийн томилгоо, сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа	ТӨБЗГ
3	Хүний нөөцийг сургах, давтан сургах үйл ажиллагаа	
4	Байгууллагын дотоод хяналтын үйл ажиллагаа	
5	Иргэдээс ирүүлсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал	

-----oO-----